АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Архангай аймгийн Булган сумын хүүхдийн цэцэрлэгийн  2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/075/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор С.Оргил<br>Утас: 77665858<br>Цахим хаяг: Shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.24 № 53

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Булган сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 10 арга хэмжээнд төсвөөс 740,479.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэл 82.3 хувь буюу 609,245.4 мянган төгрөгийг зарцуулж, 132,151.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Архангай аймгийн Булган сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 үндсэн зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 98.7 хувьтай байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 108,020,075.13 | 158,873,108.93 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 90,787,975.13 | 132,151,008.93 |
| 311 | Кассад байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 90,787,975.13 | 132,151,008.93 |
| 3121 | Төгрөг | 90,787,975.13 | 132,151,008.93 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 90,787,975.13 | 132,151,008.93 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 17,232,100.00 | 26,722,100.00 |
| 351 | Түүхий эд материал | 67,500.00 | 67,500.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 67,500.00 | 67,500.00 |
| 3513 | Эм боох материал | | |
| 354 | Хангамжийн материал | 17,164,600.00 | 26,654,600.00 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 300,000.00 | 300,000.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 16,764,100.00 | 26,254,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 100,500.00 | 100,500.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 988,502,998.67 | 1,037,000,762.44 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 988,502,998.67 | 1,037,000,762.44 |
| 392 | Биет хөрөнгө | 978,708,998.67 | 1,027,206,762.44 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,038,869,258.57 | 1,103,828,329.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -76,160,714.20 | -96,618,954.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,561,922.00 | 46,448,422.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -25,108,739.78 | -27,939,104.21 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,985,045.70 | 29,985,045.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -29,901,563.62 | -29,960,766.34 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,098,115.46 | 13,098,115.46 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -13,098,115.46 | -13,098,115.46 |
| 39217 | Ном | 1,463,790.00 | 1,463,790.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 9,794,000.00 | 9,794,000.00 |
| 39301 | Программ хангамж | 275,000.00 | 275,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -275,000.00 | -275,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,794,000.00 | 9,794,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,096,523,073.80 | 1,195,873,871.37 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,096,523,073.80 | 1,195,873,871.37 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,096,523,073.80 | 1,195,873,871.37 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 233,621,946.46 | 233,621,946.46 |
| 51101 | Өмч: - төрийн | 233,621,946.46 | 233,621,946.46 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 450,651,033.81 | 550,001,831.38 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 450,651,033.81 | 450,651,033.81 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 99,350,797.57 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 412,250,093.53 | 412,250,093.53 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,096,523,073.80 | 1,195,873,871.37 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 472,627,900.00 | 724,411,871.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,158,500.00 | 71,845,571.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,158,500.00 | 71,845,571.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 175,000.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,983,500.00 | 71,845,571.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 469,469,400.00 | 652,566,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 446,669,400.00 | 598,366,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 598,366,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 446,669,400.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 22,800,000.00 | 54,200,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 22,800,000.00 | 54,200,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 411,066,572.34 | 625,061,073.43 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 411,066,572.34 | 625,061,073.43 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 410,891,572.34 | 612,932,041.43 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 271,695,615.94 | 417,242,144.56 |
| 210101 | Үндсэн цалин | 194,323,628.67 | 296,147,079.23 |
| 210102 | Нэмэгдэл | 65,678,458.99 | 97,411,637.13 |
| 210104 | Урамшуулал | 11,693,528.28 | 23,683,428.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,158,415.63 | 54,447,740.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,623,627.36 | 35,948,163.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,661,629.01 | 4,417,126.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,101,378.36 | 2,694,495.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 518,134.84 | 2,309,610.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,253,646.06 | 9,078,344.26 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,800,000.00 | 35,242,168.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,500,000.00 | 4,743,268.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,500,000.00 | 27,998,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 2,500,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,948,900.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,948,900.00 | |
| 2105 | Нормативт зардал | 41,190,900.00 | 43,061,081.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,190,900.00 | 43,061,081.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 12,160,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 12,160,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 942,600.00 | 645,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 942,600.00 | 645,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,155,140.77 | 50,133,907.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,819,450.00 | 21,700,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,347,700.00 | 5,085,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,987,990.77 | 23,347,807.23 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 175,000.00 | 12,129,032.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 10,171,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 10,171,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 175,000.00 | 1,957,832.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 175,000.00 | 1,957,832.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 61,561,327.66 | 99,350,797.57 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 61,561,327.66 | 99,350,797.57 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 469,469,400.00 | 652,566,300.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 175,000.00 | |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 175,000.00 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 175,000.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 469,469,400.00 | 652,566,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 446,669,400.00 | 598,366,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 598,366,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 446,669,400.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 22,800,000.00 | 54,200,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 22,800,000.00 | 54,200,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 385,467,031.57 | 611,203,266.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 385,467,031.57 | 611,203,266.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 385,292,031.57 | 599,074,234.20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 271,695,615.94 | 417,242,144.56 |
| 210101 | Үндсэн цалин | 194,323,628.67 | 296,147,079.23 |
| 210102 | Нэмэгдэл | 65,678,458.99 | 97,411,637.13 |
| 210104 | Урамшуулал | 11,693,528.28 | 23,683,428.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,158,415.63 | 54,447,740.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,623,627.36 | 35,948,163.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,661,629.01 | 4,417,126.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,101,378.36 | 2,694,495.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 518,134.84 | 2,309,610.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,253,646.06 | 9,078,344.26 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,800,000.00 | 35,242,168.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,500,000.00 | 4,743,268.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,500,000.00 | 27,998,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 2,500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 41,190,900.00 | 43,061,081.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,190,900.00 | 43,061,081.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 17,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 17,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 782,600.00 | 1,672,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 782,600.00 | 1,672,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,664,500.00 | 30,408,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,316,800.00 | 25,322,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,347,700.00 | 5,085,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 175,000.00 | 12,129,032.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 10,171,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 10,171,200.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 175,000.00 | 1,957,832.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 175,000.00 | 1,957,832.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 84,147,368.43 | 41,363,033.80 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 84,147,368.43 | 41,363,033.80 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 90,787,975.13 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 90,787,975.13 | 132,151,008.93 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 233,621,946.46 | 412,250,093.53 | 450,651,033.81 | 1,096,523,073.80 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 99,350,797.57 | 99,350,797.57 |
| 10 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 233,621,946.46 | 412,250,093.53 | 550,001,831.38 | 1,195,873,871.37 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 740,479,200.00 | 609,245,434.20 | 131,233,765.80 | 82.28 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 740,479,200.00 | 609,245,434.20 | 131,233,765.80 | 82.28 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 730,308,000.00 | 599,074,234.20 | 131,233,765.80 | 82.03 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 535,200,100.00 | 417,242,144.56 | 117,957,955.44 | 77.96 |
| 210101 | Үндсэн цалин | 371,681,800.00 | 296,147,079.23 | 75,534,720.77 | 79.68 |
| 210102 | Нэмэгдэл | 151,301,700.00 | 97,411,637.13 | 53,890,062.87 | 64.38 |
| 210104 | Урамшуулал | 12,216,600.00 | 23,683,428.20 | -11,466,828.20 | 193.86 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 62,643,700.00 | 54,447,740.64 | 8,195,959.36 | 86.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,598,900.00 | 35,948,163.28 | 6,650,736.72 | 84.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,010,400.00 | 4,417,126.44 | 593,273.56 | 88.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,505,700.00 | 2,694,495.98 | -188,795.98 | 107.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,505,700.00 | 2,309,610.68 | 196,089.32 | 92.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,023,000.00 | 9,078,344.26 | 944,655.74 | 90.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 37,200,000.00 | 35,242,168.00 | 1,957,832.00 | 94.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,700,000.00 | 4,743,268.00 | 1,956,732.00 | 70.80 |
| 210302 | Түлш, халаалт | 28,000,000.00 | 27,998,900.00 | 1,100.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,500,000.00 | 2,500,000.00 | - | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 44,591,200.00 | 43,061,081.00 | 1,530,119.00 | 96.57 |
| 210502 | Хоол, хүнс | 44,591,200.00 | 43,061,081.00 | 1,530,119.00 | 96.57 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,000,000.00 | 17,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,000,000.00 | 17,000,000.00 | - | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,672,900.00 | 1,672,900.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,672,900.00 | 1,672,900.00 | - | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,000,100.00 | 30,408,200.00 | 1,591,900.00 | 95.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,914,500.00 | 25,322,600.00 | 1,591,900.00 | 94.09 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,085,600.00 | 5,085,600.00 | - | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,171,200.00 | 10,171,200.00 | - | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 10,171,200.00 | 10,171,200.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,171,200.00 | 10,171,200.00 | - | 100.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 740,479,200.00 | 650,608,468.00 | 86,200,732.00 | 88.30 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 598,366,300.00 | 598,366,300.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | 598,366,300.00 | -598,366,300.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 598,366,300.00 | | 598,366,300.00 | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 50,530,000.00 | 52,242,168.00 | -1,712,168.00 | 103.39 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 50,530,000.00 | 52,242,168.00 | -1,712,168.00 | 103.39 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 87,912,900.00 | | 87,912,900.00 | |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 87,912,900.00 | | 87,912,900.00 | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 90,787,975.13 | -90,787,975.13 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 132,151,008.93 | -132,151,008.93 | |
| 6 | Удирдах ажилтан | 2.00 | 2.00 | | 100.00 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 7.00 | 7.00 | | 100.00 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 10.50 | 10.50 | | 100.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй тул залруулга хийгээгүй.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж болон албан шаардлага хүргүүллээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

### 3.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал

*__Илрүүлэлт:__*

Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДИЙН ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ, СУРГАЛТЫН БОЛОН ЭРҮҮЛ АХУЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ"-аар хүлээн авдаг боловч бараа материалын орлого, зарлага хийдэггүй ба бараа материалын зарцуулалтын тайлан гаргадаггүй.

*__Шийдвэрлэсэн нь__: Булгийн багш нараас бүртгэлийн авч няравт хүлээлгэн өгч орлогоор бүртгэн зарцуулалтын тайлан гаргах*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" буюу 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр" 14.4.5."бүх орлого" заалтуудтай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн дагуу заавар журмыг мөрдөж ажиллаагүй байна.

2. Санхүүгийн программ

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

*Илрүүлэлт:*

Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй байна. Бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулж, анхан шатны баримтыг ихэнхийг гараар хөтөлж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т 'тасралтгүй байх' гэсэн зарчим, 13.1' Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно' гэж заасантай нийцэхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн дагуу заавар журмыг мөрдөж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Цаг тухай бүрд нь орлого зарлагын гүйлгээг программд оруулан шивж байх. Санхүүгийн программыг бүрэн эзэмших

3.3. Албан шаардлага

1. Санхүүгийн тайлагнал

*Илрүүлэлт:*

Зардлын ангилал буруу. Хоолны зардлаас ахуйн хэрэглээний төлбөрт 377.4 мянган төгрөг шилжүүлж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна

Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах:Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ий өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ийн хоол, хүнс зардлын ангилалд Тогтоосон норм, нормативын дагуу тоо хэмжээг нь тогтоосон хүнсний бүтэгдэхүүн, хоол хүнсээр / эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн хоолны зардал, цэцэрлэгийн хүүхдийн хоол, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн дотуур байрны хоолны зардал, хугацаат цэргийн албан хаагч, сэжигтэн, хоригдлын хоолны зардал, хил дээр ажиллаж байгаа офицер, ахлагчийн хүнсний хангамж/ зардал энд хамаарна гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ийг мөрдөж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "… албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материал | 1 | | - | - | - | - | 1 | | | | | |
| Санхүүгийн программ | 1 | | | | | | 1 | | | | | |
| Санхүүгийн тайлагнал | 1 | 377.4 | | | 1 | 377.4 | | | | | | |
| **Нийт дүн** | **3** | **377.4** | | | **1** | **377.4** | **2** | | | | | |